

КОНЦЕСС ЭЗЭМШИГЧДИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД МОНИТОРИНГ ХИЙСЭН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Газрын даргын 2016 оны 10 сарын 12-ны өдрийн А-09 тоот тушаалаар Засгийн газрын 2013 оны “Төрийн өмчийн Концессын зүйлийн жагсаалт батлах тухай” тогтоолоор батлагдсан концессын төсөл арга хэмжээг салбар тус бүрээр үзэж, уралдаант шалгаруулалт үнэн зөв бодитой явагдсан эсэх, хэлэлцээрийн шатанд байгаа, уралдаант шалгаруулалтаар болон шууд гэрээ хийгдсэн ажлууд, нэмэлт гэрээнүүд, цуцлагдсан төсөл хөтөлбөр, гэрээний хэрэгжилтийг нотлох баримтанд тулгуурлан шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгалаа.

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад орсон төслүүдийг салбараар нь ангилж үзвэл, авто замын чиглэлээр хэрэгжүүлэх 29 төсөл, боловсролын салбарын 121 төсөл, дэд бүтэцийн 32 төсөл, эрчим хүчний 21 төсөл, байгаль орчны 6 төсөл, эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх 14 төсөл, төмөр замын чиглэлийн 2 төсөл, мэдээлэл харилцаа холбооны чиглэлийн 3 төсөл, хоолойн тээврийн 2 төсөл, нисэх буудлын чиглэлээр хэрэгжүүлэх 4 төсөл нийт 234 төсөл хэрэгжүүлэхээр батлагджээ.

Засгийн газрын тогтоолын дагуу 117 төсөлд шууд гэрээ байгуулахаас 104 төсөлд ажлын хэсэг байгуулагдаж, ажил явагдсан бөгөөд үүнээс 99 төсөлд шууд гэрээ байгуулсан, уралдаант шалгаруулалт зарлах 102 төсөл байгаагаас 58 төсөлд шалгаруулалт зарласан байна. Нийт 234 төсөл хөтөлбөрөөс 121 төслийн гэрээг байгуулсан бөгөөд үүнээс гэрээ хүчин төгөлдөр болсон 26 гэрээ, хүчин төгөлдөр болоогүй 15 гэрээ, цуцлагдсан 80 гэрээ байна.

Уралдаант шалгаруулалт зарлагдаагүй, төсөл хэрэгжээгүй 57 төсөл, Засгийн газрын тогтоолоор хүчингүй болж хасагдсан 15 төсөл байна.

Нийт батлагдсан жагсаалтаас гэрээний дагуу ажил хийгдэж дууссан, улсын комисст хүлээлгэн өгсөн авто замын 4 төсөл байгаа бөгөөд 2 төслийн замын ажил дууссан боловч улсын комисс хүлээн аваагүй, боловсролын 1 төсөл дууссан, улсын комисс хүлээн аваагүй, дэд бүтцийн 1 төслийн 2 ажил дуусан улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Мониторингийн ажлын хэсэгт 23 төслийн материалыг хүлээлгэн өгөөгүй бөгөөд үүнээс дэд бүтцийн чиглэлийн 9 төсөлд уралдаант шалгаруулалт зарлаж, ажил хийгдсэн боловч материал хүлээлгэн өгөөгүй, бусад төсөлд тодорхой ажил хийгдээгүй гэж тайлбар өгсөн.

2014 онд концессын төлбөр болон баримт бичгийн үнийг Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн сан дахь 900036409 тоот дансанд, 2015 онд Хөрөнгө оруулалтын газрын Концессын хэлтсийн Төрийн сан дахь 900036409 дансанд, 2016 онд Хөрөнгө оруулалтын газрын Төрийн сан дахь 900036409 дансанд, Төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн 900008424 дансанд мөн Хөрөнгө оруулалтын газрын Төрийн сан дахь 900036017 дансанд төвлөрүүлж байсан байна. 2009-2013 оны санхүүгийн баримт шалгалтанд хамрагдаагүй болно.

Төрийн сан дахь 900036409 дансанд тендерийн бичиг баримтын орлого төвлөрч байсан ч тус данснаас зарлагын гүйлгээ хийдэггүй, Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн 900036403 дансанд болон Хөрөнгө оруулалтын газрын урсгал санхүүжилтийн 900036017 дансанд орлогыг буцаан төвлөрүүлэн зарлагын гүйлгээг хийж байсан байна. 2016 онд Хөрөнгө оруулалтын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд

зөвлөхийн төлбөрийг төвлөрүүлж, баримт бичгийн төлбөрийг урсгал санхүүжилтийн дансанд хуваан төвлөрүүлж байсан байна.

2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар Концессын төслүүдтэй холбоотой ирүүсэн өргөдөл гомдолыг архивын материалаас шүүхэд нийт 5 өргөдөл гомдол ирсэн бөгөөд 2 бичгийн хариуг тоотоор хүргүүлсэн байна.

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан төслүүдээс барих-шилжүүлэх /ВТ/ төрлөөр хэрэгжиж байгаа, гэрээ байгуулагдсан төслүүдийн 2016-2017 онд улсын төсвөөс буцаан авах төлбөрийг нэгтгэн харвал авто зам, эрчим хүч, мэдээлэл харилцаа холбоо, боловсрол, дэд бүтцийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслүүдийн эргэн төлөлт хамрагдаж байгаа бөгөөд 2016 онд 13.1 тэрбум төгрөг болон 6.5 сая ам доллартай тэнцэх хэмжээний төгрөг, 2017 онд 52.8 сая ам доллар, 363.4 сая юань, 35.2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс гаргахаар байна.

Концессын гэрээний төлбөрийг төгрөгөөр, америк доллараар болон юанаар хийхээр гэрээнд оруулсан нь Монгол Улсын “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн 4.1 “Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.” заалт, 4.2 “Улсын болон орон нутгийн төсөвт төлөх, төсвөөс санхүүжүүлэх аливаа төлбөр тооцоог зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх бөгөөд эдгээр төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгэхийг хориглоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Нийтлэг илэрч байгаа зөрчлүүд нь Монгол Улсын “Концессын тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 11 дүгээр зүйл “төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт”, 12 дугаар зүйл “уралдаант шалгаруулалтыг зарлах”, 13 дугаар зүйл “оролцогчийг сонгон шалгаруулах”, 14 дүгээр зүйл “төслийн санал ирүүлэх, түүнийг үнэлэх”, 15 дугаар зүйл “оролцогчтой хэлэлцээр хийх, уралдаант шалгаруулалтыг дүгнэх” заалтууд, 33 дугаар зүйлийн 33.4 “эрх бүхий этгээд уралдаант шалгаруулалттай холбоотой аливаа баримт бичиг, материалыг нэгтгэн мэдээллийн сан үүсгэж хадгална” заалт, Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам”-ын 5 “уралдаант шалгаруулалтын дараалал” заалтыг тус тус зөрчиж байна.

Барилгын ажлын явцыг 10-95 хувьтай гэж байгаа ч явцын ажлын тайлан байхгүй, барилгын чанар байдалд хяналт тавьсан талаар тайлан мэдээ, албан тоот байхгүй, нотлох бичиг баримт байхгүй учир хэрэгжилтийн хувийг тодорхой авч үзэх боломжгүй байна. Барилгын ажил дуусч санхүүжилтээ авах хүсэлтээ концесс эзэмшигчид гаргаж байгаа байдлыг харгалзан нэн ялангуяа, гэрээ хүчин төгөлдөр болоогүй боловч барилгын ажил хийгдэж байгаа ажлуудын барилгын чанар байдалд явцын хяналтыг хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай байна.

Нэг тушаалаар олон төслийн уралдаант шалгаруулалтыг зарлах, үнэлэх, гэрээний хэлэлцээр хийх ажлын хэсгийг байгуулж байгаа нь ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга нарын ажлын ачаалалыг үл тооцсон, уралдаант шалгаруулалт үр дүн муутай, дутуу хагас явагдсан, бичиг баримтын хөтлөлт болон бүрдэл хангалтгүй байх нөхцөл бүрдсэн байна. Ажлын хэсэг хийсэн ажлын тайлангаа гаргаж тайлагнадаггүй, ажлын хэсгийн ажлыг дүгнэж байгаагүйгээс дээрх зөрчил дутагдлууд гарч байгаа бөгөөд хийсэн ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлсний үндсэн дээр нэмэгдэл цалин, урамшуулал олгох асуудлыг шийдэх нь зүйтэй.

Ажлын хэсгийн гишүүдийн урамшуулалыг нэг хүнд 300.0 мянган төгрөгөөс-5.0 сая төгрөгөөр тогтоож олгосон бөгөөд ямар үндэслэл, хууль журмын дагуу урамшуулалын дүнг тогтоож, олгож байгаа нь тодорхойгүй, тушаалд тодорхой үндэслэл байхгүй байна.

Тус албанд одоогоор 4 мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд ажлын ачаалал, хувиарлалтыг харгалзан 2 хүртэлх тооны хяналт, бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэнүүдийг нэмж ажиллуулан төслийн байнгын хяналтыг хэрэгжүүлэн удирдлагыг мэдээллээр ханган ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Баримт бичгийн хадгалалт хамгаалалт хангалтгүй, бичиг баримтыг үдэж архивладаггүй, товъёоглодоггүй, задгайгаар хадгалдгаас бичиг баримт дутах, алга болох, солигдох нөхцөл бүрдсэн байгаа тул бүх бичиг баримтыг цэгцлэж товъёоглон, архивлах ажлыг яаралтай хийж дуусгах шаардлагатай.

Төслүүдтэй холбоотой зөрчлүүд нь шалгалтанд хүлээлгэн өгсөн баримтанд /хавсралт 1/ тулгуурлан гарсан бөгөөд мэргэжилтнүүдийн ажил хүлээлцсэн байдал удааширсан, ажилтайгаа бүрэн танилцаагүйгээс нэмэлт тодруулгыг асуухад хангалтгүй байсан бөгөөд ажлаа гүйцэд хүлээн авч танилцаагүй, өмнөх мэргэжилтний ажлын эмх цэгц тааруу байснаас төслийн материал эмх замбараагүй, зарим төсөл шалгалтанд хамрагдаагүй болно.

Тус албаны концессын ажлуудын гүйцэтгэлийг үйл ажиллагааны эрсдэл, санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналт гэсэн 3 үндсэн чиглэлийн дагуу 13 шалгуур үзүүлэлтээр эрсдлийн үнэлгээ хийж үзэхэд /хавсралт 2/ шаардлага хангаагүй буюу их эрсдэлтэй /80.7хувь/ үнэлэгдэж байна.

Цаашид, төслийн явц, гэрээний хэрэгжилт, барилгын чанар байдалд мэргэжлийн байгууллагуудаар болон /хөндлөнгийн/ аудитын байгууллагаар хяналт шалгалт хийлгэх шаардлагатай.

ХШҮДАА.
2016.11.16